



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.17 оны 02 сарын 10-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн 2016 оны санхүүгийн үр дүнг харгалзан, компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Говь” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9 дэхь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

Нэг. “Говь” ХК-ийн 2016 оны цэвэр ашгаас хувьцааны нэгж тутамд 200 (хоёр зуун) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоож, ногдол ашгийг 2017 оны 4 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн компани дээрээ бэлэн мөнгөөр тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгохыг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д даалгасугай.

Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

Гурав. Компанийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахтай холбоотой гарах зардлыг холбогдох зардлын төсвөөс гаргахыг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэд даалгасугай.

ТУЗ-ЫН ДАРГА

ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Т.ОДМАА

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН